

**ОЧИРВААНЬ-ОТГОНТЭНГЭР ХАЙРХАН ШҮЛЭГ НАЙРАГТ
ДҮРСЛЭГДСЭН НЬ[◎]**

Г. Галбаяр^{*}

Оршил

Нүүдлийн мал аж ахуй эрхэлж, байгаль дэлхийн ерөнхий хууль жамыг даган ажиллаж амьдарч ирсэний хувьд монголчууд уул усаа хүндлэн дээдэлж, сүслэн залбирч ирсэн ард түмэн. Байгалийн хуулийг дагах нь нүүдэлчдийн сэтгэлгээгээр аливаа ажил үйлс сансанчлан бүтэх, дэлгэрэхийн утгатай. Энэ сэтгэлгээ, амьдралын хэв заншил нь эргээд байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, унаган төрхөөр нь дараа үедээ үлдээх үндэс нь юм.

Ертөнцийн хууль, зүй тогтолын дагуу эрхэлж буй аж ахуйн эрхээр байгальтай нарийн шүтэн барилдаж амьдарч ирсэн уламжлалтайн хувьд монгол хүн бүрийн сэтгэлд ямар нэг уул ус уяатай байж түүндээ сүслэн залбирч явдаг. Монгол хүн бүрийн амнаас “Унасан газар минь, угаасан ус минь”, “Хүй дарсан хүрэн чулууг хадгалсан нутаг минь” гэсэн үгс ундарч байдаг нь санамсаргүй хэрэг биш. Саяхан бид твиттерээр нийтийн дунд “Хувьдаа шүтээж залбирч явдаг уул устай эсэх, түүний утга учир”-ын талаар асуулт өрнүүлэхэд олон хүн идэвхитэй оролцож бүгд “Уугуул юмуу суугуул нутгийнхаа аль нэг уул хайрханыг санаж түүндээ залбирч, хувь заяагаа даатгаж явдаг” тухайгаа бичиж байв. Тийм ч учраас хол газар яваа хүн нутгийн чулуунаас авч явдаг заншилтай. Дээрх твиттерийн асуулгаар гадаадад амьдарч буй хүмүүсээс “Нутгийн уул усны чулуугаа биедээ авч явдаг” эсэхийг асуухад хариу бичсэн хүмүүсийн 85 орчим хувь нь авч яваа гэж хариулсан төдийгүй Улаанбаатар юмуу өөр нэг хот сууринд амьдарч буй иргэд ч өөрийн нутгийн уул усны чулуунаас биедээ заавал авч явдаг тухайгаа бичсэн байна. Өвгөд дээдсийн хуучилсан хууч яриагаар бол “Хол газар явах үедээ нутгаа их санаад ирэхээр авч яваа нутгийн чулуугаа долооход эсвэл аяга саванд хийж байгаад дээр нь ус хийгээд тэр усыг уухад нутгийн үнэр ханхалаад, сэтгэл сайхан болдог” гэнэ. Хөх ногооны униар татсан хавраар эсвэл сөл ялгарсан намраар нутгаасаа хол газар яваа монгол хүн, монгол морь хоёрын сэтгэлд төрж өссөн нутаг нь илүүтэй санагдаж, тэр зүгт тэмүүлдэг жамтай нь нэгийг өгүүлнэ.

Байгаль дэлхий, өсөж төрсөн нутгийнхаа уул устай хүйн холбоотой байж, түүндээ үйл амьдрал, хувь заяагаа даатган сүслэн залбирч явахдаа сэтгэлийн эрхэм нандин торгон хөг аялгуу, ухаарал бэлгэдлийн илэрхийллээ үгээр урлан дархалж, сэтгэл итгэлийн таашаалд умбаж, ажил амьдралын замналаа үргэлжлүүлэн хөөх нь хүмүүний амьдралын жам. Монгол урлаг, уран зохиолд газар газрын уул хайрхан, ус ургамлын

[◎] This work was supported by Hankuk University of Foreign Studies Research Fund of 2012

^{*} Visiting Professor of Hankuk University of Foreign Studies, Korea

дүр зураг дүрслэгдэн мөнхөрч, өөр өөрийн өнгө дүрээр ямар нэгэн гоо сайхан, үлгэр домгийг хүүрнэн байдаг. Уул хайрханыг шүлэг найрагт дүрслэн түүнийг магтан дуулж хуурдахдаа аль аль талыг нь онцлон үздэг сэтгэлгээ, тэр нь цаанаа ямар утга учрыг илэрхийлэн байдаг хийгээд энэ бүхэн нийт утга зохиолын хөгжилд хэр хувь нэмэртэй зэргийг жишээ болгон тодруулж үзэх үүднээс энэ удаа Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы дүр дүрслэлийн тухай тодруулан үзэв.

Богд Очирваань-Отгонтэнгэр уулыг монголчуудыг даасан Очирваань бурханы оршдог хайрхан гэж үздэг. Богд Очирваань-Отгонтэнгэр нийт монголчуудын гол шүтээн хайрхан тул тэдний шүлэг найрагт энэ хайрханы дүр нэн түгээмэл. Бид энэ удаад Отгонтэнгэрийн Дархан Цаазат Газрын хамгаалалтын захиргааны дарга Д. Батдэлгэрийн эмхэтгэсэн *“Дуу, шүлгэнд мөнхөрсөн Очирваань-Отгонтэнгэр”* (Хэзээ, хаана хэвлэгдсэн нь тодорхойгүй. Доторх бүтээлүүдийг ажиглавал 2009-2010 онд хэвлэгдсэн бололтой.) түүврийн хүрээнд ажиглалт, судалгааг хийсэн болно.

I. Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы тухай

Монгол орны баруун хэсэг Завхан аймгийн Алдархаан, Отгон сумдын нутагт Хангайн нурууны ноён оргил болох Отгонтэнгэр уул сүндэрлэнэ. Тэр хайрханыг нутгийхан төдийгүй нийт монголчууд *“Богд Очирваань хайрхан”* хэмээн хүндэтгэн нэрлэж заншжээ. Энэ нэрээр нэрлэх болсон нь Монгол дахь буддын шашны гурав дахь дэлгэрэлтийн үе буюу 1585 орны орчмоос эхтэй болох тухай судлаачид¹ тэмдэглэсэн байна. Хэдийгээр буддын шашны ойлголтоор энэ үеэс уг хайрханыг хүндэтгэн дээдэлж ирсэн нь тодорхой ч орчин тойрноо хайрлан хамгаалж, уул усандаа идээ будааныхаа дээжийг өргөн, сүслэн залбирч, хувь заяатайгаа холбон үзэж түүгээрээ дамжуулаад байгаль дэлхийгээ хайрлан хамгаалдаг эртний уламжлалтайн хувьд монголчууд нэн эрт үеэс уг хайрханыг дээдэлж байсан нь тодорхой биз. Түрэгийн хаант улсын үед уг хайрханы ойр орчмоос эмийн ургамал түүж эрчилгээнд хэрэглэж байснаас гадна гол нуурын ус нь элдэв өвчин эмгэгийг анагаах увдистай тухай тэдний ном зохиолд тэмдэглэгдэн үлдсэн байдаг байна. Энэ нь нэн эрт үеэс эл хайрханыг монголчууд хүндэтгэн үзэж, өвс ургамал, рашаан ус нь элдэв өвчин анагаах бололцоотойг нь нээн илрүүлж амьдрал ахуйдаа хэрэглэж байсны илрэл биз.

Богд Очирваань хайрханыг 1828 онд дархан цаазтай болгож, жил бүр тахин тайж байх болсон байна. Энэ уламжлал 1930-аад оноос 1995 он хүртэл тасарсан түүхтэй. 1995 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн (П. Очирбат) 110 тоот зарлиг гарч Богд Очирваань хайрханыг дөрвөн жил тутам нэг удаа төрийн их ёслол хийн тахиж байхаар болжээ. Энэ зарлигын дагуу 1995, 1999, 2003, 2007, 2011 онд таван удаа тахив. Монголчуудын уул хайрхан тайж тахиx ёслол нь *“орчлон ертөнцийн гүнзгий далд чанадын зүй тогтол, жам ёсыг танин барьж, ухааран ойлгож, улмаар түүнд аж амьдрал, ахуй нөхцөлөө зохицуулж ирсэн гүн ухаан, ёс жудаг, заншил бэлгэдлийн цогц үйлдэл”*² юм.

¹ Сүхбат П. (2004) *Богд Очирваань Отгонтэнгэр хайрханы түүх шастир, тайлга тахилга, зан үйлийн товчоон оршвой*. П. Улаанбаатар.,

² Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж, (2011) *Отгонтэнгэр уулын төрийн тахилгын ёслол дээр хэлсэн үг*. www.news.mn сайтаас.,

Богд Очирваань хайрхан түүний ойролцоох 955 хавтгай дөрвөлжин талбай бүхий газрыг Монгол Улсын Их Хурлын тусгай тоглоолоор 1992 онд Төрийн тусгай хамгаалалттай дархан цаазат газар болгожээ. Энэ тусгай хамгаалалтын газарт төв Азийн өндөр уулын бүсийн экосистем ноёлохоос гадна мөлгөр оройт уулс, оройгоодоо сийргэшсэн ой мод, газрын гүний эрдэс баялаг бүхий цэнгэг гол нуур, гүн балчиг намаг шалбааг ихтэй. Энэ нь эртний мөстлөг, мөсөн голын үндсэн шинжүүдийг хадгалж байдаг тухай мэргэжлийн судлаачдын бүтээлд бичигдсэн байна. Богд Очирваань хайрханы дархан цаазат газрын хад чулуу ихтэй нутгаар нэн ховордсон аргал (*Ovis ammon*), янгир (*Capra sibirica*), ирвэс (*Uncia*), хүдэр (*Moschus moschiferus*), халиун буга (*Cervus elaphus*) зэрэг зэрлэг амьтад, олон нууранд нь гангар хун (*Cygnus*), хээрийн галуу (*Anser indicus*) болоод бусад олон төрлийн ховор усны шувууд зусдаг байна.

Газар зүйн шинжлэх ухааны үүднээс Отгонтэнгэр уулыг дундад Азийн хамгийн отгон галт уул гэж үздэг ажээ. Завхан, Идэр зэрэг монголын баруун зүгийн олон томоохон голууд эндээс эх авч урсаад хүн, амьтан төдийгүй олон нуур, цөөрмийг тэтгэн сэлбэж байдаг.

I.I. Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы тухай түүх домог

Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы тухай олон түүх домог нутгийн ардуудын дунд бий. Эдгээрийн заримыг товч тайлбартайгаар өгүүлье. Эл хайрханы үүсэл гарлын тухай нутгийнхан:

"...Эрт дээр цагт Богд Дүнжингарав уул одоогийнхоосоо огт өөр уул байсан гэнэ. Мөнх цастай, мөсөн дуулгат орой нь хөх тэнгэр баганадсан, цасан мөнгөн цээжнээс нь доохнуур үүл хоноглон, уур савсан, түүнээс дооших биеийг нь ногоон ой хучсан үзэсгэлэнтэй уул байжээ. Чингэтэл хангай нутгийн баруун тал ус чийгээр дутагдаж, ган гачигт нэрвэгдсэн аж. Энэ үеэр хүн амьтныг ган гачгаас аврах нэгэн их бяртай эр тэнд төржээ. Тэр баатар эр Богд Дүнжингаравыг зорин ирж, тэхий дундуур нь оосорлож үүрээд бостол цээжин бие нь тасраад ирж гэнэ. Тэгэхээр нь "Дургүй бөгс нь эндээ үлдэг, дуртай цээжийг нь аваад явъя" гээд үүрч алхсаар Хангайн нуруун дээр аваачиж тавьжээ. Ийнхүү энэ үеэс Богд Дүнжингаравын мөнх цаст цагаан орой Хангайн нурууны ноён оргил Богд Очирваань-Отгонтэнгэр гэсэн нэртэй болж, мөнх цэвдэг тэр уулын мөс хайлж, тал талаас нь олон гол урсан ган гачигт нэрвэгдээд байсан нутаг орон, зон олныг ундлан тэтгэсэн ажээ."

хэмээн өгүүлдэг байна. Энэ домогт Монгол нутгийн хоёр ариун дагшин хайрханыг ерөнхий тогтоцоор нь холбон уран сайхнаар домогложээ. Богд Дүнжингарав хайрханы орой хэсгийн налгар хавтгай тогтоцыг Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы эгц цавчим оргил өндөртэй холбон домогчилсон нь нэг талаар ерөнхий тогтоц байрлалтай нь холбоотой ч цаанаа олон түмэн сүслэн дээдэлж, тахин шүтэж байдаг хайрханууд хоорондоо холбоотой байдаг тухай үзэл сэтгэлгээний илэрхийлэл юм.

Богд Очирвааний эргэн тойронд Чулуут, Хонгор морьт, Хатан бэйл зэрэг эгц цавчим олон даваа бий. Эдгээр даваанууд бүгд түүхэн домогтой. Тухайлбал Хатан бэйлийн давааны домог нь:

"...Эрт цагт Хошууч бэйсийн хошуунд Хуйхуу нар довтлон орж ирэхэд хошууны ноён хатнаа дагуулан өмнө талын асга чулуут даваагаар даваад зугтсан гэнэ. Ноёны хойноос хөөж явсан хүмүүс өндөр газрын сүрд цохигдон уг даваагаар

давж чадалгүй буцжээ. Ийнхүү хошуу ноёны амийг аварсан сүрлэг сайхан давааг нутгийн ард Хатан бэйлийн даваа хэмээн нэрлэх болсон домогтой. Уг даваа маш огцом өндөр тул түрүүчийн морины хомоол дараагийн морьтой хүний толгой дээр унадаг гэлцдэг. Бүр зарим нь уг давааны нэг хэсэг газар морьтой давж болдоггүй, мориноосоо буугаад сүүлнээс нь зүүгдэж давдаг гэж хууцлах нь ч бий."

Хатан бэйлийн давааны домог нь түүхэн үйл явдлаас үүсэлтэй. Монголчууд газар нутгаа гадаад талын ямар нэг онцлог шинж, дотоод хүч чадал тогтоц хийгээд түүхэн бодит үйл явдлуудтай холбон нэрлэж, алдаршуулж байсны илэрхийллийн нэг нь эл давааны тухай домог.

Нутгийнхны нэрлэдгээр Цагаан уулын ойролцоох бүх зүйлс хоорондоо уялдаа холбоотой бас бүгд домогтой. Тухайлбал, Хайрханы зүүн бэл дэх аварга том яст мэлхий лугаа адил хадыг Мэлхий хад гэнэ. Мэлхий хадны домог нь:

"...Баруун өмнө зүг чиглэсэн байрлалтай Мэлхий хад нь Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханыг гадны муу муухай бүхнээс авран хамгаалан оршдог гэсэн домогтой. Тиймд нутгийнхан Хайрханаа хамгаалана гэдэг нь Мэлхий хадыг хамгаалахын нэр хэмээн ихэд хүндэтгэн үзэж, арц хүжээ уугиулан, идээ будааныхаа дээжийг өргөн шүтдэг байна. Тиймд нутгийнхан Мэлхий хаднаас дээш явахыг ихэд цээрлэнэ".

Хайрхан уул амар амгалан, ариун дагшин байхын тулд өөрийгөө хүч чадал, урт удаан амьдралын бэлгэдэл болсон зүйлсээр хамгаалуулан оршдог тухай нутгийн олны үзэл бодол домгийн хэлбэрээр илэрсэн нь энэ. Энэ мэт домог болон яригдаж, тахигдаж шүтэгдсэн олон газар ус нэгдэн нийлж Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы тухай цогц ойлголтыг бий болгодог байна.

I.II. Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы ерөнхий тогтоц, бэлгэдлийн утга

Богд Очирваань хайрханы оргил далайн түвшинөөс 4021 метр өндөрт өргөгдсөн бөгөөд түүний 3752 метрээс дээш өндөр нь мөнх цастай. Өвөг дээдсийн яриагаар тэнгэр бурханаас Замбуулинд таван их тэнгэр уул хайрласны отгон нь Отгонтэнгэр хайрхан хэмээн бэлгэдэн хуучилдаг. Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы тогтоцыг нутгийн олон төдийгүй зорьж очсон хүмүүс хоёр янзаар сэтгэлдээ буулган тольдож сүслэн тайлбарласан байдаг. Нэг хэсэг хүмүүс */энд ихэвчлэн нутгийн иргэд/* зузаан цагаан алчуур зангидаж нялх хүүхдээ тэвэрсэн эх хүний дүртэй хэмээн өгүүлдэг. Энд мөнх цаст оргилыг нь цагаан алчуур, эгц цавчим элгэн тал дахь Бадархундага нуурыг нь эхийнхээ өвөр дээр үнэгчлэн нойрсоо үр хүүхэдтэй зүйрлэн өгүүлсэн хэрэг. Энэхүү ойлголт дүр зургийн цаана Богд Очирваань-Отгонтэнгэр хайрхан бол дөнгөж төрсөн эх хүн шиг ариун дагшин, эмзэг торгомсог учир үргэлж сүслэн залбирч, хайрлан хамгаалж байхын бэлгэдэл утга илэрхий. Нөгөө нэг хэсэг хүмүүс */ихэвчлэн сүсэгтэн олон/* жанчаа нөмөрч эрдэм ухаанаа бясалган суугаа бурханы дүртэй хайрхан хэмээн өгүүлдэг. Бурханы шашныг сүслэн дээдэлж, сургаал номлолыг нь дагаж мөрддөг шавь хүний үүднээс сэтгэлийн гүн, бодлын чинад хязгаартаа цагаан өнгөтэй мөнх цасыг эерүүлэн шар өнгөтэй жанч хэмээн бэлгэдэн сольж, уул хайрханы ерөнхий дүр төрхийг бурхан хэмээн шүтээнчлэн сэтгэж өгүүлжээ. Буддын шашны нэрт зүтгэлтэн Бакула Ренбучи Багштан 1991 онд Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханыг хэрэг болгон зорьж ирээд

“Отгонтэнгэр хайрханыг онгоцоор нар зов тойрч харлаа. Яг л жанчаа нөмрөөд заларч суугаа Очирваань бурханы дүр харагдаж байна” хэмээн айлдсан байдаг.

Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханыг тойрсон 8 цэнгэг нуур байдаг. Эдгээр нуурууд нь найман тахилын бэлгэдэлтэй аж. Очирваань хайрханы зүүн бэлд баруун өмнө зүг харсан аварга том яст мэлхийн хэлбэр бүхий харлаг хад байдаг. Тэр хадыг нутгийнхан “Мэлхий хад” хэмээн нэрлэх бөгөөд Очирваань хайрханыг гадны элдэв халдлагаас хамгаалдаг хэмээн бэлгэдэн ойлгодог тухай дээр өгүүлсэн.

Очирвааний оргилд ил байдаг уулсын хормой бэлээр онцгой өнгө, үнэр бүхий хонин арц ургадаг. Арцыг гишгэх, мөрчийг гэмтээхийг нутгийнхан эрс цээрлэнэ. Арцыг авахдаа тусгай зан үйл үйлдэж, Очирваань бурханы  /Ум базар бани хум/ гэсэн зүрхэн тарнийг уншиж, хормой дэвсэн сөхөрч суугаад алга хавсран оргил өөд нь мөргөж авдаг заншилтай.

Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы ерөнхий бүтэц дүр зураг нь үр хүүхдээ энхрийлэн хайрлах эх юмуу ном бясалгаж буй хуварга, орчин тойрон нь буддын шашны үндсэн гол ойлголтууд болох найман тахил, зуун найман эрхи, суварга зэрэг цогц бэлгэдэлт дүртэй болохыг олон түмэн ажиглаж сүслэн залбирдаг байна. Монголчууд Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханыг нэгэн үзүүрт сэтгэлээр сүслэн дээдэлж явбал сүслэн дээдлэгчийн есөн үеийг нь элбэрлийн сахиусандаа багтааж авран хамгаалдаг хэмээн бэлгэшээдэг.

II. Богд Очирваань-Отгонтэнгэр хайрхан шүлэг найрагт дүрслэгдсэн нь

Монголын уран зохиолд Богд Очирваань-Отгонтэнгэр, Бурхан Халдун, Богд Дунжингарав гээд монгол нутгийн хувь заяа, хүн зоны аж амьдралд чухал хувь нэмэртэй алдарт хайрхануудаас эхлээд энгийн нэг талын бор толгой хүртэл дүрслэгдэн, өөр өөрийн гоо сайхан тогтоц, увдис шидээрээ гайхуулан байх аж. Тэдний олон янзын дүр зургийн хослол дахь бахархан бардамнах, баярлан сүслэх өнгө аяс хоршин уялдаж монголын утга зохиолын хөгжилд түрлэг нэмэх нь өвөрмөц. Уул хайрхануудын дүр дүрслэл дэх ерөнхий болоод тусгай онцлогийг олон талын уялдаа холбоонд нь тодруулан үзэж уран зохиолын хөгжил хувьсалд оруулж буй хувь нэмрийг тодруулах нь чухал ач холбогдолтой. Учир нь эндээс монгол хүний уул ус, ургамал ногоогоо хайрлан хамгаалах, сүслэн дээдлэх нарийн ур ухааны ундарга, учир холбогдол тодрох нь дамжиггүй. Улмаар тэдний аж амьдрал, соёл сэтгэлгээний түүхэн хөгжил хувьсал тус бүрдээ ялгаран илүү гүн тодрон харагдах талтай. Бид энэ удаад дээр өгүүлсэнчлэн зөвхөн Богд Очирваань-Отгонтэнгэр хайрхан шүлэг найрагт хэрхэн дүрслэгдсэнийг товч авч үзэж байгаа билээ.

II.I. Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы гадаад дүр зураг шүлэг найрагт дүрслэгдсэн нь

Яруу найрагч Жавын “Оройн чимэг” шүлэг Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы магтаал дуулал болон алдаршсан бүтээл. 33 бадаг бүхий уг шүлэгт шүтээн хайрханыхаа дүр зургийг:

“Оройн чимэг болсон

Отгон хайрхан уул

Огторгуйн чимэг болсон

Энх тайвны оргил ...

*Орой биеийг нь харахад
Оточ бурханы байдалтай
Дугарга цагаан цас нь
Духалзан мяралзан харагдана ...”*

/Дуу, шүлгэнд мөнхөрсөн Очирваань-Отгонтэнгэр. Эмхэтгэсэн Отгонтэнгэрийн Дархан Цаазат Газрын хамгаалалтын захиргааны дарга Д. Батдэлгэр. 7 дугаар тал. Жич: Хойно авсан шилэлүүдийг өгүүлэн буй эмхэтгэлээс авсан тул зөвхөн хэддүгээр талаас авсаныг тэмдэглэсэн болно/ гэх зэргээр монгол нутаг дахь өндөр хайрхануудын ноён оргил нь Богд Очирваань-Отгонтэнгэр болохыг түүх домгийн өгүүлэмжийн үүднээс алдаршуулан дуулсан байна. Өөрөөр хэлбэл олон тэрбум жилийн тэртээ дэлхий ертөнц дүүрэн ус байгаад бага багаар шимэгдэн анхны хуурай газар үүсэхэд өнөөгийн монгол нутгаас хамгийн анх Отгонтэнгэр хайрхан цухуйсан гэдэг үзэл баримтлал, домог яриаг уран сайхны сэтгэлгээний үүднээс баталгаажуулан монгол нутгийн хамгийн өндөр хайрханы нэг хэмээн дүрслэхийн зэрэгцээ олон түмний дүрслэх сэтгэлгээ, шүтлэг бишрэлийн үүднээс бурханы дүртэй мөнх цаст хайрхан гэдэгтэй уялдуулан хослуулж дүрсэлсэн нь яруу найрагт сэтгэлгээ, бишрэл, дүрслэлийн олон талын онцлогийг цогцоор нь нэг цул болгон уран сайхнаар илэрхийлж болдогийг харуулна. “Оройн чимэг” шүлэгт цааш нь:

*“Дунд биеийг нь харахад
Дуган сүмийн байдалтай ...
Аржгар ногоон арц нь
Арван зүгтээ ганхана ...
Баруун уулын орой дээр
Бар ирвэс агсарна
Зүүн уулын оройн дээр
Зүр гур зөрөлдөнө ...”*

гэх зэргээр дээр өгүүлсэн орой хэсгийн дүр дүрслэлээс орон зайн хувьд доошлуулан хүрээ хязгаарыг нь тэлэхийн зэрэгцээ дотоод мөн чанар руу нь ярган орж увдис шидэнд нь шилжин уран сайхнаар дүрсэлсэн байна. Энэхүү дүрслэлээс үзвэл Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы дунд хэсгээс доош элдэв олон төрлийн ан амьтан амьдарч, байгалийн олон төрлийн онцгой сонин дүр төрх үүсэж, тэнд хүн амьтныг анагаан эмчлэх ид шидтэй өвс ургамал, рашаан ус элбэг байхаас гадна эл хайрхан нийтдээ олон түмнийг хайрлан хамгаалж, ивээл илчээ түгээх өвөрмөц увдистай болохыг алдаршуулан дуулж магтжээ.

Монгол улсын төрийн шагналт, Урлагийн гавъяат зүтгэлтэн Б. Шарав, С. Цэвээнлхазал нарын бүтээл “Хааны титэм шиг Отгонтэнгэр” бүтээлд:

*“Оргил өндөр хайрхануудаар
Хормой билээ түшиүүлсэн
Огторгуй цагаан үүлсийг
Дурдан бүс шиг ороосон
Хангайн их уулсын минь
Мөнгөн буурал тэргүүн
Халхын уудам нутагт минь
Хааны титэм шиг Отгонтэнгэр ээ ...” /11 дүгээр тал/*

хэмээн ертөнцийн хамгийн өндөр уул хайрхануудаар хормой бэлээ түшүүлэн тэр хэрээрээ газрын хүйснээс тасарч огторгуйн мандалд умбаж, огторгуйн үүлсийг бүслэн хааны титэм шиг эрхэмсэг залрахын зэрэгцээ хиргүй тунгалаг ариун дагшин байж, тэр тэнгэрлэг ариун дагшин шинжээ эргүүлээд орчлон дэлхий, олон түмэндээ зориулдаг болохыг урнаар өгүүлжээ. Монгол хүний сэтгэлгээнд аливаа зүйлийг хамгийн түрүүнд буурь сууриа гүн бат эзэлж авахыг ихэд чухалчилдаг. Хамгийн энгийнээр монгол үндэсний бөхөд барилдахаар гарах бөхийг хашир туршлагатай засуул, олон жил барилдсан бөх, бөхийн барилдаан үзэж сурсан үзэгчид зогсоц, буурь суурийг нь хараад л тэгэж ингэж барилдах хүн байна хэмээн шинждэг. Мөн бодит амьдрал, судар шасдираас үзвэл монгол хүн аливаа уул усаа нарийн бат шинжихдээ хамгийн түрүүнд ерөнхий тогтоц, суурийг онцгой чухалчлахыг заасан байдаг. Энэ үүднээс Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханыг шүлэг найрагт дүрслэхдээ гайхамшигтай бат сайн суурьтай болохыг уран сайхны үүднээс олон янзаар илэрхийлэн харуулсан байна. Өгүүлэн буй *"Хааны титэм шиг Отгонтэнгэр"* бүтээлд хүчирхэг эрэлхэг хааны титэм шиг эрхэмсэг, эрх мэдэлтэй, ариун дагшин бат суурьтай хайрхан болохыг өгүүлсэн бол П. Батсайхан, Монгол улсын гавъяат жүжигчин С. Батсүх нарын бүтээл *"Дорны намуун Отгонтэнгэр"* шүлэгт:

*"Цэнхэр замбууланд дахин мэндэлсэн
Цэцгий нь үнэрээр нутгаа тэмцэнэ
Луун суудалтай суварга ууландаа
Лусын гөрөөс шиг цахилаад очно
Тэнгэр байтлаа тэргэл ижий минь
Тэрлэг дээлэнд нь багтаад түшидэг дээ
Хөх тэнгэр минь, Отгонтэнгэр минь
Сүлдэт уул аа" /20 дугаар тал/*

гэж монгол хүний домогчлон бэлгэдэх сэтгэлгээний хамгийн хүчтэй амьтан болох лууны суудалтай зүйрлэн өгүүлсэн байна. Хүчирхэг луун суудлыг уулсын ерөнхий дүр, олон түмний сүслэн дээдлэх сэтгэлгээтэй уялдуулан суварга хэлбэрийн дүрслэлтэй хослуулсан нь улам уран сайхантай болж хүний сэтгэлд хүрэх шинж нь нэмэгдсэн байна. Бидний бодоход луу хүчирхэг байдаг гэж бэлгэдэн үзэх үзлийн үндэс нь буурь суурь сайтайд нь байдаг биз. Луун суудалтай тэнгэр баганадсан суварган хайрхан сүр хүч, сүлд хиймориороо хэн хүнийг бишрүүлэх ч эргээд хэн хүнийг ивээх хайр энэрэл, увдис шидээрээ төрсөн эхээс нь өөрцгүй болохыг зохиомжийн уран сайхны өвөрмөц боловсруулалт хийж урласан нь шүлгийн үнэ цэнэд чухлаар нөлөөлжээ.

С.Нямзагд, Ардын жүжигчин, Төрийн хошой шагналт Н.Жанцанноров нарын бүтээл *"Отгонтэнгэр минь"* бүтээлд:

*"Цаст цагаан оргилыг тань
Зүүдлэн зүүдлэсээр ирлээ
Цал буурал аавтайгаа уулзах шиг боллоо
Цамнан буух горхиноос чинь амслаа
Цайлган ээжийнхээ сүүг амсах шиг боллоо
Уулсын минь тэргүүн
Отгонтэнгэр минь
Ухааны минь тэргүүн
Отгонтэнгэр минь" /15 дугаар тал/ ...*

унаж төрсөн уул уус гэдэг хүүгийнхээ сэтгэлд үргэлж мөнх уяатай баяж, баярлахад хамт баярлаж, гунихад хамт гуниж байдаг онцлогтойг нөгөө талаас төрж өссөн нутаг гэдэг өвөг дээдэс, эцэг эхийнх нь онгон сүлдийг чинад нарийн, эрхэмсэг ариун хадгалж байдгийн хувьд хүүгийн сэтгэлд өвөг дээдэс, эцэг эхийг нь орлон байж цаг ямагт даллан дуудаж, ирэх бүрийд тэднийг нь орлон ивээл хайр, эрх хүчийг хайрлан байдаг далд мөн чанарыг нээн өгүүлсэн байна. Үүний зэрэгцээ хүний хувь заяа төрсөн нутгийн уул ус, ургамал ногоотой хамааралтай болохыг өгүүлсэн нь сонирхолтой болжээ. Өөрөөр хэлбэл зохиолчийн эрүүл саруул байж, эрдэм ном сайн сурч, амжилт бүтээл гаргаж яваа нь төрсөн нутаг Богд Очирваань-Отгонтэнгэр хайрхантайгаа салшгүй холбоотой болохыг илэрхийлсэн гэсэн үг. Бодит амьдрал дээрх энгийн яриа, шинжлэх ухааны сүүлийн үеийн ололт амжилтан дахь баталгаа нотолгооноос харахад хүний ухаан санаа, хүч чадал төрсөн нутаг уснаас ихээхэн хамааралтай аж. Тийм ч учраас Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханыг тойроод хутагт хувилгаад, эрдэмтэн мэргэд олноороо төрсөн байдаг нь санамсаргүй хэрэг биш биз.

Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы дүр зургийг:

“Дунчүүр оддыг оргилдоо зулаад

Дүүрэн сарыг энгэртээ эрхлүүлдэг

Гүнгэрваатай бурхан шиг заларсан

Биндэрьяа эрдэнийн Отгонтэнгэр хайрхан ...

Төрийн тахилгатай Лусын шүтээн

Төгөлдөр Монголын домгийн шүтээн

Удган цагаан зандантай зүйрлэмээр

Уулсын хаан Отгонтэнгэр хайрхан” /16 дугаар тал/

(Д. Лхагвасүрэн, Б. Мөнхжаргал нарын бүтээл “Уулсын хаан Отгонтэнгэр”) хэмээн одод шүргэн цайвалзсан уулс хайрхануудын хаан нь болон заларсан эрхэмсэг, эрдэнийн их орон болохыг онцлон өгүүлсэн бол Д. Болдхуяг “Огторгуйн чимэг” бүтээлдээ:

“Замбуу тивээс ургасан атлаа

Захгүй хурмастын сарыг очир болгон атгасан

Ертөнцийн хөрснөөс бүрэлдсэн байтлаа

Ерөн есөн тэнгэрийн отгон дүү хэмээгдсэн ...

Бэлд нь монголын дөрвөн улирал бууриа сэлгэх атал

Оргилд нь үргэлжийн дөрвөн цагт хаж монгон өвлөөрөө” ... /28 дугаар тал/

гэх мэтээр энэ болоод дээд ертөнцийг холбон залрах ерөнхий төрхийг “Дээд тэнгэрээс энэ ертөнцөд хайрласан таван их хайрханы отгон нь Отгонтэнгэр” гэсэн домог яриатай холбон шүлэглэсэн нь сонирхолтой болжээ. Улмаар “монх цаст монгон зулайт” маш өндөр хайрхан болохыг монгол нутгийн жилийн дөрвөн улирлын ээлжлэн солигдох өнгө аястай уялдуулан уран сайхны өвөрмөц аргаар яруу тансаг шүлэглэн өгүүлсэн нь энгийн хэрнээ гайхалтай дүрслэл болсон байна. Мөн яруу найрагч Х.Лхасүрэн “Очирваань уул” шүлэгтээ:

“Ойртох тутам өндөршиж

Оргил нь үл харагдах

Холдох тусам намссан

Хоймрын бурхан шиг залрах Очирваань ...” /47 дугаар тал/

хэмээн өгүүлжээ. Монголчууд аливаа зүйлийг шинжихдээ гайхамшигтай ард түмэн. Тэдний шинжээгээр сайн бөх, сайхан тогтоцтой уулс хоёр холдох тутам тодорч, ойртох тутам үл ойлгогдох, үл танигдах шинжтэй байдаг гэнэ. Өвөг дээдсийн уул хайрханаа

шинжин таних нарийн ур ухааныг өөрийн олон янзын ажиглалтын үр дүнд сэтгэлдээ тодорсон хөрөг дүртэй уялдуулан урласан нь өвөрмөц байна.

Дээр өгүүлсэнчлэн Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы гадаад дүр зургийг уран сайхны үүднээс олон янзаар тэр дундаа маш өндөрт өргөгдсөн мөнх цаст үзэсгэлэнт хайрхан болохыг, хайрхан уул эх газрын хээлэнд гүн бат, бат суурьтай залрах нь сүр хүч, сүлд хийморийнх нь язгуур үндэс болохыг, хайрханыг тойроод байгалийн сонин сайхан тогтоц бие биенийхээ хүйн холбоонд бүрэлдэн бий болсон нь хэн хүний сэтгэлд дотно байдгийг харж болохоор байна.

II. II. Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы дотоод мөн чанар шүлэг найрагт илэрхийлэгдсэн нь

Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханыг шүлэг найрагт өгүүлэхдээ гадаад дүр төрхийн онцлогийг уран сайхнаар олон талаас нь нээн дүрсэлж, магтан дуулсанаас гадна дотоод мөн чанар, увдис шидийг нь сүслэн дээдэлж учирлан илэрхийлсэн нь нэн элбэг.

Яруу найрагч Ц. Бавуудорж, Ц. Нэргүй нарын бүтээл “Заяа даасан Отгонтэнгэр” бүтээлд:

*“Эрдэнийн тахилгат Бадархундагатай
Эрдэмт мэргэдийн бадарсан хийморьтой
Билиг оюуны мөнхийн адистай
Биеийг минь бүүвэйлсэн нарны диваажин
Хутагт төрдөг нарны орон
Хувилгаад ирдэг бурхдын орон
Завхан нутаг арцны үнэртэй
Заяаг минь даасан Отгонтэнгэр ...” /9 дүгээр тал/*

хэмээн Отгонтэнгэр хайрханы оргилын доод талд далайн төвшнөөс дээш 3000 метрийн өндөрт оршдог, нутгийн иргэдийн домогчлон ярих яриагаар бол “Отгонтэнгэр хайрханы тахилын аяга” гэгддэг ариун дагшин нуурыг домог яриа хийгээд түүхэн бодит үйл явдалтай уялдуулан өвөрмөц уран сайхан, утга агуулгаар шүлэглэжээ. Өөрөөр хэлбэл сүслэн дээдэлсэн хэн хүний хүслийг биелүүлдэг хэмээн домогчлон өгүүлдэг Бадархундага нуурыг зорьж очсон хүмүүс үнэт эрдэнийг хадганд боон өргөж тахин тайж хүслээ шивнэдэг түүхэн үйл хэргийг олон талын уялдаа холбоонд өгүүлсэн байна. Улмаар Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханд хувь заяагаа даатган, ариун дагшин арц хүчээр нь ариулж, рашаан булгаас нь хүртсэн хэн хүний заяа тавиланг үеийн үед дааж ивээдэг болохын нууцыг уран сайхны үүднээс учирлан дээдэлж өгүүлжээ.

Ер нь Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы орчмыг эх газрын хээл, тэнгэр огторгуйн олон огтлолцол заагаас ялгарах сайн сайхан энергийн уулзвар цэг хэмээн өгүүлдэг. Үнэндээ ч Монголын олон арван хутагт хувилгаад, эрдэмтэн мэргэд, генерал жанжнууд энэ хайрханыг тойрон мэндэлсэн нь санамсаргүй хэрэг биш биз. Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы энэхүү увдис шид, хайр энэрлийг олон бүтээлд тал талаас нь магтан дуулж, учирлан тайлбарлаж өгүүлсэн аж. Тэдгээрийн дотроос яруу найрагч Ц. Бавуудорж, Монгол Улсын Гавьяат жүжигчин Н. Чулуунхүү нарын бүтээл “Очирваань уулын цагаан үүл” уран сайхан дүрслэл, утга агуулгын хослолоороо өвөрмөц болжээ.

*“Очирваань уулын цагаан үүл нь
Орчлонд намайг дагаж нүүдэг дээ
Мөнхийн ногоон арц нь хүртэл
Мөр замыг минь хучиж ургадаг*

Орчлонд нэг ийм сайхан хангай бий

Очирваань минь гээд залбирахад

Оюун бодол минь тэнгэрлэг болдог юм ...” /12 дугаар тал/

гэж сүслэн дээдэлж чадаж гэмээ нь Очирваань хайрхан газрын хол ойроос үл хамааран хишиг буянаа хүртээж, хайрлан хамгаалж байдаг увдистайг өгүүлэхийн зэрэгцээ сайн сайхан үйл, үнэн шударга ажил амьдралд орон зайн хэмжээ чухал биш болохыг өгүүлсэн хэрэг. Өөрөөр хэлбэл ертөнцөд хайрлан энэрэх сайн сайхан энерги жигд тархсан нэг цогц ойлголт болохыг шүтэн биширч, залбирч явдаг хайрханыхаа увдис шидэд тулгуурлан өгүүлсэний хувьд уг шүлэг нэн гүн утга агуулгатай юм. Дээр нь утга агуулгын урлалаа шүтээн хайрханыхаа хөг аялгуу, өнгө төрхийн хослолоос үүдэлтэй дуу авианд буулган тэгш хэмнэл, хөг аялгууг үүсгэн ар араасаа утга санааг урлан зангидаж ундарсан сэтгэлийн дуулал болгож чадсан нь нэн үнэ цэнэтэй. Шүлгийн төгсгөлд:

“Очирваань уулын цагаан оргил нь

Орчлонд намайг түшиж явдагдаа

Алтан мутартай хутагт хувилгаад нь

Амгалан тавиланг минь адислаж байдаг” /12 дугаар тал/

хэмээн Очирваань хайрхан хайрлан хамгаалж, сүслэн дээдлэгч олноо ивээж, муу муухайгаас хамгаалаад зогсохгүй хайрханы увдис шидийг авч мэндэлсэн хутагт хувиргаад, эрдэмтэн мэргэд бие биенээсээ эхлүүлээд эгэл түмнийг нэгэн үзүүрт сэтгэлээр энэрч ивээж байдгийг орон зайн төгс хослолд хүрээ хязгаарыг нь тэлүүлэн өгүүлж чадсан нь бүр ч гойд урлал болжээ.

Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханаас ундарсан олон рашаан, Вансэмбэрүү тэргүүтэй олон ургамал, Завхан, Идэр тэргүүтэй гол мөрөн олон түмнийг ундаалах, эмнэн эмчлэх шидтэйг олон шүлэг найрагт алдаршуулан магтаж, баярлан өгүүлсэн байна. Тухайлбал, Мэндбаярын бүтээл *“Отгонтэнгэр ууландаа би хайртай”* бүтээлд:

“Амьдрал тэтгэх анагаах увдистай

Алаг цэцэгс нь хосоор амилсан ...” /6 дугаар тал/

гэж үзье, олъё гэсэн хүнд тэр бүр үзэгдэж, олдоод байдаггүй харин үзэгдэх, олдох хүндээ хичнээнээрээ үзэгдэж, олддог гэгддэг Вансэмбэрүү цэцгийн анагаах эмчлэх шидийг магтан дуулсан байхад яруу найрагч Ц. Дэгджав *“Амин эрдэнийн оточ хайрхан”* шүлэгтээ:

“Амин эрдэнийн рашаан нь байхад

Ард олон минь амгалан байхад

Ариун арц нь анхилам байхад

Аз хийморьтой явахаас ч яахав

Дархалж тахисан зарлигтай байхад

Даяар монгол нь шүтэхээс ч яахав дээ” /14 дүгээр тал/ хэмээн олон

түмнийг анагаах шидтэй рашаан булаг, цог хийморийг бадраах хүчтэй арц хүжийн сайхныг алдаршуулан төр түмнийхээ итгэл сэтгэл, зарлиг уухайтай холбон өгүүлсэн байна.

Мөн Г. Цогбадрах, П. Бямбадорж нарын бүтээл *“Онгод хөглөсөн уул”* бүтээлд:

“Очирваань ууландаа залбирахад

Оюун ухаан бадардаг

Ойртож харах бүрийд

Онгод хийморь сэргэдэг

Орчлонд ганцхан хайрхан минь

Онгод хөглөсөн шүтээн уул аа ...” /23 дугаар тал/

гэх мэтээр сүслэн залбирч явахад сэтгэл санаа ариусаж, муу муухайг бодож хийхийн аргагүй төгөлдөр төлөвшилийг олж, ухаан санаа бадарч, хийж бүтээх эрч хүч, итгэл найдвараар дүүрч, урам зориг ундардаг нь Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы ач тус, увдис шид болохыг сэтгэлийн хөгөөрөө магтан дуулсан байна.

“Дуу, шүлгэнд мөнхөрсөн Очирваань-Отгонтэнгэр” түүвэрт орсон бүтээлүүдийг нэгтгэн авч үзвэл Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханыг тойроод хутагт хувилгаад, эрдэмтэн мэргэд олноороо төрж, нутаг нугын ард түмэн амгалан тайван, эрүүл энх сайн сайхан аж төрдөг нь энэ хайрханы тогтоц, дотоод мөн чанар дахь ид шид, увдистай нь холбоотой болохыг уран сайхны үүднээс нээн илрүүлэхэд, хайрхан уулаа алдаршуулан магтахад гол анхаарлаа хандуулсан байна. Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханыг тойроод орших уул хайрхан, рашаан булаг, ургамал ногоо бүгд хүмүүний сэтгэлийг ариусган, өвчин зовлонг эмнэн эдгээх шидтэй байдгийг олон талаас нь учирлан магтаж өгүүлжээ.

Дүгнэлт

Монголчуудын соёл, сэтгэлгээний илэрхийлэл болсон урлаг, уран зохиолд уул усаа хайрлан хамгаалж, сүслэн дээдэлсний тусгал хамгийн их байдаг байна. Монгол урлаг, уран зохиолд газар газрын уул хайрхан, ус ургамлын дүр зураг дүрслэгдэн мөнхөрч, өөр өөрийн өнгө дүрээр ямар нэгэн гоо сайхан, үлгэр домгийг хүүрнэх аж. Уул хайрханыг шүлэг найрагт дүрслэн, түүнийг магтан дуулж хуурдахдаа аль талыг нь онцлон үздэг сэтгэлгээ, тэр нь цаанаа ямар утга учрыг илэрхийлэн байдаг хийгээд энэ бүхэн нийт утга зохиолын хөгжилд ямар хувь нэмэртэй зэргийг жишээ болгон тодруулж үзэх үүднээс Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы дүр дүрслэлийн тухай тодруулан үзвэл доорх хэдэн зүйл тодорхой харагдаж байна.

Нэг, Монгол хүн байгаль дэлхий, төрж өссөн нутагтайгаа нэн ойр байж, түүнийгээ хайрлан хамгаалж, шүтэн биширч ирсэн өвөрмөц зан заншил, соёл сэтгэлгээтэй. Уг үйл явдлын учир утга, мөн чанарыг тал талаас нь тодруулж үзэхэд монгол хүн байгалийн ерөнхий хуулийг дагаж, тэр хуулийн дагуу ажиллаж амьдрахыг чухалчилдаг нь тодорхой байна. Энэ нь эргээд нутаг орон, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах язгуур хөрс суурь нь болдог аж.

Хоёр, Нутаг орныхоо уул хайрхан, ус мөрний тогтоц, онцлог мөн чанарыг уран сайхнаар илэрхийлэн учир утгыг нь тайлбарлах үүднээс домогчлон сэтгэх, улмаар бэлгэдэн тайлбарлах нь тэдний үзэл бодол, сэтгэлгээний төлөвшилд чухал нөлөөтэй аж.

Гурав, Монгол уран зохиолд Богд Очирваань-Отгонтэнгэр хайрханы тухай дүрслэхдээ гадаад хэлбэр тогтоц, хүний аж амьдралд хэрхэн нөлөөлөх дотоод мөн чанар талаас нь голлон өгүүлсэн байна. Гадаад талын онцлогийг гаргахдаа ямар нэг зүйлтэй харьцуулан жишихэд дулдуйдсан ч тус тусдаа ялгарсан уран хурц дүрслэл давамгайлж байгаа бол дотоод мөн чанар буюу хүний сэтгэлд буусан шинж чанар, ач

буян, үр өгөөжийг өгүүлэхдээ нэгээс нөгөө нь урган гарсан бясалган бодсон гүн сэрэл мэдрэмжид тулгуурласан энгийн дүрслэл зонхилж байна.

Уус усны өвөрмөц тогтоц, утга учрыг нь тайлах гэсэн энэ мэт дүрслэл нь нэг уул хайрханыг алдаршуулаад зогсохгүй нийт уран зохиолын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулдаг ач холбогдолтой нь тодорхой байна.

НОМ ЗҮЙ

1. Дамдинсүрэн. Ц. (1959) *Монголын уран зохиолын дээж зуун билиг оривой*. Улаанбаатар.,
2. Дамдинсүрэн. Ц. (1957) *Монголын уран зохиолын тойм*. I боть. Улаанбаатар.,
3. Дамдинсүрэн. Ц. нар (1977) *Монголын уран зохиолын тойм*. II боть. Улаанбаатар.,
4. Дамдинсүрэн. Ц. нар 1968 *Монголын уран зохиолын тойм*. III боть. Улаанбаатар.,
5. Дуу, шүлгэнд мөнхөрсөн *Очирваань-Отгонтэнгэр*. Эмхэтгэсэн Д.Батдэлгэр.
6. *Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх*. (1968) Улаанбаатар.,
7. *Монголын орчин үеийн уран зохиолын түүх*. ., (1985, 1989, 1998) I-III боть. Улаанбаатар.,
8. *Монголын соёлын түүх*. (1999) I-III боть. Улаанбаатар.,
9. Сүхбат П. (2004) *Богд Очирваань Отгонтэнгэр хайрханы түүх шастир, тайлга тахилга, зан үйлийн товчоон оривой*. II. Улаанбаатар.,
10. <http://www.otgontenger.mn>
11. <http://www.zavkhan.gov.mn>
12. <http://www.news.mn>
13. <http://www.olloo.mn>
14. <http://www.sonin.mn>
15. <http://www.shuud.mn>
16. <http://www.mongolianbooks.com>
17. <http://www.travelnews.mn>
18. <http://www.archaeology-sos.blogspot.com>
19. <http://www.touristinfocenter.mn>

SUMMARY

In art and literature, which are considered to be as main expressions of Mongolian culture and thinking, a respect and preference for nature, a desire to protect mountains and rivers are largely reflected. Scenes of mountains, rivers, plants from different places are kept forever in mind of Mongolian literature and thanks to their variety of individual styles they narrate about the various myths, beauties and fairy tales. In order to determine what sides are looked upon and what implicit meanings are expressed in description and praise of mountains in poems and songs, as well as what contributions these expressions make to the development of literature, we have profoundly studied description about Bogd Ochirvaani Otgontenger mountain and revealed the following aspects.

One, the Mongolians have a rich and specific culture and tradition that teaches to be close to nature, protect and worship the places in which they were born. If, to consider the meaning and value of these events from different sides, it is clear that the Mongolians prefer complying general natural law and follow the way of living style as specified by this law. This, conversely, became a basis of love for nature and the earth.

Two, on purpose to impressively and emphatically express the structure and specific properties of mountains and rivers and to explain their meanings, the Mongolians preferred to make legends and symbolize. This had a significant role for their view and thinking.

Three, description about the Bogd Ochirvaani Otgontenger mountain mainly narrates from the side of external structure as well as internal properties that influence to human living style. In order to express the external features of the mountain, comparisons are used between the mountains and other things, comparisons in which precise and expressive descriptions are dominated. Whereas, to express internal properties or consequences and efficiency reflected in human mind, simple descriptions based on deep feelings caused by mediation, contemplation and deep thought are prevailed.

It is clear that such descriptions aiming to ascertain the meaning and specific structure of mountain and rivers not only glorify mountains, but also play a significant contribution to the development of literature generally.